

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/34/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalaid@audit.gov.mn">enkhdalaid@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:enkhjargalts@audit.gov.mn">enkhjargalts@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: <a href="mailto:dabg.audit@gmail.com">dabg.audit@gmail.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	15
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн .....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	17
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	21
5.1 Албан шаардлага .....	21
5.2 Зөвлөмж.....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОУ	Олон Улсын
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХА	Харьцуулалтын арга
ЧҮСШ	Чадавхад үндэслэсэн сонгон шалгаруулалт
ЧСШ	Чанарт суурилсан сонгон шалгаруулалт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН  
ХОЛБОЛТ БА ЛОГИСТИКИЙГ  
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  
Б.ОЮУНДЭЛГЭР ТАНАА

2026.04.02 № 06/307  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21,177,363.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны эцэст замын барилгын их засварын гэрээний урьдчилгаа төлбөр тооцоо 21,153,853.1 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Гадаад зээл, тусламжийн төслүүдийн үр ашиг, бүтээмжийг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын 7.8-д гадаад зээл, тусламжийн төслүүдийг эрэмбэлэх, хэрэгжилт, ашиглалтыг сайжруулах, төслийн менежментийн тогтолцоонд өөрчлөлт оруулж, тусгайлсан төслийн нэгжүүдийг Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалтад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн хүрээнд хэрэгжих ажил, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба эхний ээлжид төслийн Бүрэлдэхүүн-1 хэсэг буюу зам, гүүрийн засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Үүний үр дүнд зам барилгын засварын ажлын нийт 285,793,809.2 мянган төгрөгийн 6 гэрээ байгуулж, 21,153,853.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Улсын их хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу гадаадын зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх шийдвэрийн дагуу Сангийн яамнаас төслийн хүрээнд хэрэгжүүлэх зарим зөвлөх үйлчилгээг хойшлуулах чиглэл өгсөн тул төслийн Бүрэлдэхүүн-2 хэсэг Логистикийн үйлчилгээний хүрээнд хэрэгжих зөвлөх үйлчилгээг Дэлхийн банк болон Зам, тээврийн яам зөвшилцөж, шийдвэрлэх шаардлага үүссэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*C. Naranchimeg*

Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,569,560,015.45</b>	<b>25,536,688,818.07</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,569,244,015.45</b>	<b>4,382,835,678.08</b>
31200	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2,569,244,015.45</b>	<b>4,382,835,678.08</b>
31210	<b>Төгрөг</b>	<b>12,688,268.78</b>	<b>112,694,495.14</b>
31211	Төрийн сангийн харилцах	12,688,268.78	112,694,495.14
31220	<b>Гадаад валют</b>	<b>2,556,555,746.67</b>	<b>4,270,141,182.94</b>
31221	Төрийн сангийн харилцах	2,556,555,746.67	4,270,141,182.94
33	<b>АВЛАГА</b>	<b>316,000.00</b>	-
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	316,000.00	-
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	-	<b>21,153,853,139.99</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	-	21,153,853,139.99
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>117,770,059.73</b>	<b>57,204,032.93</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>117,770,059.73</b>	<b>57,204,032.93</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>111,172,798.93</b>	<b>54,606,770.63</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,198,420.00	109,198,420.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,522,944.42)	(76,122,148.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,661,160.00	25,199,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,163,836.65)	(3,668,661.05)
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>6,597,260.80</b>	<b>2,597,262.30</b>
39301	Программ хангамж	8,000,000.00	8,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,402,739.20)	(5,402,737.70)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>2,687,330,075.18</b>	<b>25,593,892,851.00</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>316,000.00</b>	<b>73,320.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>316,000.00</b>	<b>73,320.00</b>
41300	<b>Өглөг</b>	<b>316,000.00</b>	<b>73,320.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	316,000.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	73,320.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,687,014,075.18</b>	<b>25,593,819,531.00</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,687,014,075.18</b>	<b>25,593,819,531.00</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,687,014,075.18</b>	<b>25,593,819,531.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-	2,687,014,075.18
51220	Тайлант үеийн үр дүн	2,687,014,075.18	22,906,805,455.82
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>2,687,330,075.18</b>	<b>25,593,892,851.00</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>23,631,960,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>23,631,960,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>23,631,960,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>23,631,960,000.00</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,381,230,000.00	23,629,260,000.00
120009	Бусад орлого	4,830,872.00	2,700,000.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>728,766,812.39</b>	<b>877,984,459.54</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>728,766,812.39</b>	<b>877,984,459.54</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>728,766,812.39</b>	<b>877,984,459.54</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>541,088,934.78</b>	<b>611,985,111.11</b>
210101	Үндсэн цалин	541,088,934.78	611,985,111.11
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,636,116.85</b>	<b>76,498,138.89</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	45,992,559.46	52,018,734.44
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,410,889.35	6,119,851.11
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,705,444.67	3,059,925.56
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,705,444.67	3,059,925.56
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,821,778.70	12,239,702.22
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,256,298.66</b>	<b>56,773,320.00</b>
210304	Байрны түрээс	38,256,298.66	56,773,320.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,059,096.93</b>	<b>11,164,993.64</b>
210401	Бичиг хэрэг	9,279,460.00	3,604,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,779,636.93	7,560,693.64
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,323,200.00</b>	<b>376,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,323,200.00	376,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,880,000.00</b>	<b>23,510,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,880,000.00	23,510,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,433,644.90</b>	<b>36,572,869.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,433,644.90	31,572,869.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,089,520.27</b>	<b>61,104,026.80</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,089,520.27	61,104,026.80
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,657,294,059.61</b>	<b>22,753,975,540.46</b>
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>30,087,081.48</b>	<b>205,786,311.34</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	30,087,081.48	205,786,311.34
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>367,065.91</b>	<b>52,956,395.98</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	367,065.91	52,956,395.98
VII	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>29,720,015.57</b>	<b>152,829,915.36</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>2,687,014,075.18</b>	<b>22,906,805,455.82</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>2,700,000.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>2,700,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>2,700,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,386,060,872.00</b>	<b>2,700,000.00</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,381,230,000.00	-
120009	Бусад орлого	4,830,872.00	2,700,000.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>704,677,292.12</b>	<b>811,366,695.64</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>704,677,292.12</b>	<b>811,366,695.64</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>704,677,292.12</b>	<b>811,366,695.64</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>541,088,934.78</b>	<b>611,985,111.11</b>
210101	Үндсэн цалин	541,088,934.78	611,985,111.11
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,636,116.85</b>	<b>76,498,138.89</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	45,992,586.96	52,018,734.44
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,410,904.35	6,119,851.11
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,705,364.67	3,059,925.56
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,705,452.17	3,059,925.56
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,821,808.70	12,239,702.22
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,256,298.66</b>	<b>56,700,000.00</b>
210304	Байрны түрээс	38,256,298.66	56,700,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,059,096.93</b>	<b>11,164,993.64</b>
210401	Бичиг хэрэг	9,279,460.00	3,604,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,779,636.93	7,560,693.64
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,323,200.00</b>	<b>538,000.00</b>
210602	Тавилга	-	538,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,323,200.00	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,880,000.00</b>	<b>23,510,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	14,880,000.00	23,510,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,433,644.90</b>	<b>30,970,452.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,242,906.90	18,164,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,190,738.00	7,806,052.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,681,383,579.88</b>	<b>(808,666,695.64)</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>141,859,580.00</b>	<b>21,153,853,139.99</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>141,859,580.00</b>	<b>21,153,853,139.99</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>141,859,580.00</b>	<b>21,153,853,139.99</b>
220001	Барилга байгууламж	-	21,153,853,139.99
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	141,859,580.00	-

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(141,859,580.00)</b>	<b>(21,153,853,139.99)</b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>30,087,081.48</b>	<b>23,835,046,311.34</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	30,087,081.48	205,786,311.34
1451	<b>Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах</b>	-	<b>23,629,260,000.00</b>
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	23,629,260,000.00
25	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>367,065.91</b>	<b>58,934,813.08</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	367,065.91	52,956,395.98
250006	Бусад зардал	-	5,978,417.10
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>29,720,015.57</b>	<b>23,776,111,498.26</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>2,569,244,015.45</b>	<b>1,813,591,662.63</b>
101	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>2,569,244,015.45</b>
20	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,569,244,015.45</b>	<b>4,382,835,678.08</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-
Тайлант үеийн үр дүн		2,687,014,075.18	2,687,014,075.18
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	<b>2,687,014,075.18</b>	<b>2,687,014,075.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>3,537,991,575.18</b>	<b>3,537,991,575.18</b>
Тайлант үеийн үр дүн		22,906,805,455.82	22,906,805,455.82
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	<b>25,593,819,531.00</b>	<b>25,593,819,531.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,969,522,000.00</b>	<b>21,965,219,835.63</b>	<b>4,302,164.37</b>	100.0
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>814,522,000.00</b>	<b>811,366,695.64</b>	<b>3,155,304.36</b>	99.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>814,522,000.00</b>	<b>811,366,695.64</b>	<b>3,155,304.36</b>	99.6
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>612,000,000.00</b>	<b>611,985,111.11</b>	<b>14,888.89</b>	100.0
210101	Үндсэн цалин	612,000,000.00	611,985,111.11	14,888.89	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,500,000.00</b>	<b>76,498,138.89</b>	<b>1,861.11</b>	100.0
210201	Тэтгэврийн даатгал	52,020,000.00	52,018,734.44	1,265.56	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,120,000.00	6,119,851.11	148.89	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,060,000.00	3,059,925.56	74.44	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,060,000.00	3,059,925.56	74.44	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,240,000.00	12,239,702.22	297.78	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>56,700,000.00</b>	<b>56,700,000.00</b>	-	100.0
210304	Байрны түрээс	56,700,000.00	56,700,000.00	-	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,965,000.00</b>	<b>11,164,993.64</b>	<b>1,800,006.36</b>	86.1
210401	Бичиг хэрэг	4,240,000.00	3,604,300.00	635,700.00	85.0
210402	Тээвэр, шатахуун	525,000.00	-	525,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,200,000.00	7,560,693.64	639,306.36	92.2
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>550,000.00</b>	<b>538,000.00</b>	<b>12,000.00</b>	97.8
210602	Тавилга	550,000.00	538,000.00	12,000.00	97.8
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>24,000,000.00</b>	<b>23,510,000.00</b>	<b>490,000.00</b>	98.0
210702	Дотоод албан томилолт	24,000,000.00	23,510,000.00	490,000.00	98.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,807,000.00</b>	<b>30,970,452.00</b>	<b>836,548.00</b>	97.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,000,000.00	18,164,400.00	835,600.00	95.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,807,000.00	7,806,052.00	948.00	100.0
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,155,000,000.00</b>	<b>21,153,853,139.99</b>	<b>1,146,860.01</b>	100.0
220001	Барилга байгууламж	21,155,000,000.00	21,153,853,139.99	1,146,860.01	100.0
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(21,969,522,000.00)</b>	<b>(21,965,220,135.63)</b>	<b>(4,301,864.37)</b>	100.0
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>21,969,522,000.00</b>	<b>21,965,220,135.63</b>	<b>4,301,864.37</b>	100.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(1,664,039,864.37)	1,664,039,864.37	-
72	<b>ЗГ-ын зээл</b>	<b>21,969,522,000.00</b>	<b>23,629,260,000.00</b>	<b>(1,659,738,000.00)</b>	107.6
722	<b>Гадаад</b>	<b>21,969,522,000.00</b>	<b>23,629,260,000.00</b>	<b>(1,659,738,000.00)</b>	107.6
7221	<b>Төслийн зээл</b>	<b>21,969,522,000.00</b>	<b>23,629,260,000.00</b>	<b>(1,659,738,000.00)</b>	107.6
322101	Шинээр авах	21,969,522,000.00	23,629,260,000.00	(1,659,738,000.00)	107.6

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,569,244,015.45		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,382,835,678.08		
6	<b>Төсвийн бусад мэдээллийн ангилал</b>				
61	<b>Байгууллагын тоо</b>	<b>1</b>	<b>1</b>	-	
62	<b>Ажиллагсдын тоо</b>	<b>15</b>	<b>11</b>	4	73.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	14	10	4	71.4

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны хооронд 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 9336-MN дугаартай зээлийн гэрээ, 7039-MN дугаартай санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийг Зам тээврийн яам нь 5 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ.

Төслийн зорилго нь Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй зам, тээврийн дэд бүтцийн холболтыг сайжруулах замаар Монгол Улсын хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн бүтээгдэхүүн махны тээвэр, логистикийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулна.

Төслийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт: Улсын чанартай нийт 361 км авто зам, нийт 1205 у/м, 8 гүүрийг шинэчлэн сайжруулах засварын ажил, нийт 51 км 2 сумыг холбох орон нутгийн чанартай авто зам барих болон хөрөнгийн менежментийг сайжруулах санал, зөвлөмж, дүрэм, журам боловсруулах;
2. Логистикийн үйлчилгээ: Зорилтот 8 аймагт чиглэгдсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүн дотроо махны зах зээл, экспортыг дэмжих логистикийн үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн ТЭЗҮ боловсруулах, логистикийн сүлжээний платформ хөгжүүлэх, инновац нэвтрүүлэх туршилтын төсөл, программ хөгжүүлэх, холбогдох эрх зүйн орчны бий болгоход чиглэгдсэн дүрэм, журам, стандарт боловсруулах;
3. Техник туслалцаа, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа: Авто замын хөрөнгийн менежментийг сайжруулах, логистикийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сургалт, семинар зохион байгуулах, бодлогын баримт бичиг, дүрэм, журам боловсруулах;
4. Болзошгүй онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл нь Автозамын тухай хууль, Барилгын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”;

- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаанд Дэлхийн банкны явцын хяналтууд хийгдэж, харъяа яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрддөг бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,906,562.8 мянган төгрөгөөр буюу 8 дахин өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,569,244.0	4,382,835.7	1,813,591.7
Авлага	316.0	-	(316.0)
Бусад эргэлтийн хөрөнгө	-	21,153,853.1	21,153,853.1
Үндсэн хөрөнгө	117,770.1	57,204.0	(60,566.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,687,330.1</b>	<b>25,593,892.9</b>	<b>22,906,562.8</b>
Өр төлбөр	316.0	73.3	(242.7)
Хуримтлагдсан үр дүн	2,687,014.1	25,593,819.5	22,906,805.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,687,330.1</b>	<b>25,593,892.9</b>	<b>22,906,562.8</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,382,835.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,813,591.7 мянган төгрөгөөр өссөн нь 9336-MN зээлийн гэрээ, 7039-MN санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу тайлант онд хүлээн авсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 21,153,853.1 мянган төгрөг байгаа нь тайлант онд А0501 Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 68 км, А0302 Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 35 км, А0301 Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 105 км, А0502 Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто замын засварын ажил гүйцэтгэх 4 гэрээний урьдчилгаа төлбөрүүд байна.
- Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 25,593,819.5 мянган төгрөг болж, тайлант оны үр дүн 22,906,805.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлийн санхүүжилтээс 169,839,876.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, 2024 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 26 дугаар албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас хөрөнгийн зардлын 32,333,428.8 мянган төгрөгөөр бууруулж, урсгал зардлыг 186,079.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 137,692,528.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Сангийн яамнаас 2024 оны 01/10803 дугаар албан тоотойр УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолын дагуу гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байх чиглэл ирүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант оны 12 дугаар сард гүйцэтгэлээс хамааруулан хөрөнгийн зардлыг 114,759,157.8 мянган төгрөг, урсгал зардлыг 963,848.3 мянган төгрөг, нийт 115,723,006.1 мянган төгрөгөөр бууруулж 21,969,522.0 мянган төгрөг болгон тохируулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг гадаад зээлийн эх үүсвэрээс 21,969,522.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн эх үүсвэрээс 23,629,260.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийт зардлын гүйцэтгэл 21,965,219.8 мянган төгрөг буюу 100.0 байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

<i>/мянган төгрөг/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>70207-Гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр</b>	<b>21,969,522.0</b>	<b>21,965,219.8</b>	<b>4,302.2</b>	<b>100.0</b>
1.1	80104-Гадаад зээлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	21,969,522.0	21,965,219.8	4,302.2	100.0

**Судалгааны үр дүн:** Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

**1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар**

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн батлагдсан орон тоо 15, гүйцэтгэлээр 11 хүнтэй ажиллаж, тайлант оны цалингийн зардал 612,000.0 мянган төгрөг төсөвтэй, гүйцэтгэлээр 611,985.1 мянган төгрөг зарцуулсан;

**2. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:**

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 8,000.0 мянган төгрөгийн төсөвтэй санхүүгийн программ ашигладаг.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Монгол улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн хүрээнд улсын чанартай гол авто замын сүлжээний насжилт өндөртэй, ашиглалтын бэлэн байдлын түвшний үзүүлэлт буурсан Хөвсгөл, Булган, Архангай, Өвөрхангай, Төв, Увс, Хэнтий, Сүхбаатар зэрэг 8 аймгийн нутаг дэвсгэр дэх Улаанбаатар-Арвайхээр, Арвайхээр-Баянхонгор, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл, Улаанбаатар-Өндөрхаан, Өндөрхаан-Чойбалсан, Булган-Мөрөн чиглэлийн нийт 361 км авто зам, тус чиглэлүүд дэх Хэрлэн, Орхон, Тамир, Гичгэн, Хануй, Бэлх, Түргэн зэрэг голууд дахь нийт 7 байршлын 1205 урт метр төмөр бетон гүүрт их засвар болон ээлжит засварын ажил хийгдэж, орон нутгийн чанартай 51 км хатуу хучилттай авто зам шинээр баригдах ба төсөл хэрэгжсэнээр авто замын сүлжээний аюул осолгүй, ая тухтай, үр ашигтай зорчих нөхцөл эрс дээшилж, тээвэр ашиглалтын зардал буурах, цаг хугацаа хэмнэх, цаашлаад сүлжээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Төслийн үйл ажиллагааг 2024 оны 02 дугаар сараас эхлүүлсэн ба 2024 онд төслийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн бөгөөд 2025 онд Бүрэлдэхүүн-1 хэсэг дэх зам, гүүрийн засварын ажлын хүрээнд нийт 7 багц хэсгийн 13 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр зам барилгын ажлын 6 гэрээ, зам, гүүрийн засварын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээний 1 гэрээг байгуулж гүйцэтгэгчид ажлын талбайг хүлээлгэж өгөх, зураг төсөл боловсруулах зэрэг барилгын ажлын бэлтгэл хангаж ажилласан байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 4 бүлгийн 60 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тайлант оны эцэст төсөл хөтөлбөрийн нийт гүйцэтгэл 94.8 хувь байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
<b>1. Ажил</b>								
1	Дотоодын нээлттэй тендер шалгаруулалт	6	40,440,528.0	-	-	-	6	40,440,528.0
2	Олон улсын нээлттэй тендер шалгаруулалт	7	295,535,268.0	6	285,793,809.2	85.7	1	9,741,458.8
<b>2. Зөвлөх үйлчилгээ</b>								
3	Дотоодын нээлттэй тендер шалгаруулалт- Чадавхад үндэслэсэн сонгон шалгаруулалт	1	5,212,440.0	-	-	-	1	5,212,440.0
4	Олон улсын нээлттэй тендер шалгаруулалт- Чадавхад үндэслэсэн сонгон шалгаруулалт	2	16,387,560.0	1	13,563,537.8	50.0	1	2,824,022.2
5	Дотоодын -Чанарт суурилсан сонгон шалгаруулалт	2	1,008,000.0	-	-	-	2	1,008,000.0
<b>3. Бараа</b>								
6	Харьцуулалт арга - Дотоод	1	34,891.2	-	-	-	1	34,891.2
<b>Дүн</b>		<b>19</b>	<b>358,618,687.2</b>	<b>7</b>	<b>299,357,347.0</b>	<b>36.8</b>	<b>12</b>	<b>59,261,340.2</b>

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 295,535,268.0 мянган төгрөгийн 7 ажлын худалдан авалтыг олон улсын НТШ-ын аргаар худалдан авахаар төлөвлөснөөс 285,793,809.2 мянган төгрөгийн 6 худалдан авалтыг зохион байгуулж 85.7 хувийн гүйцэтгэлтэй, 16,387,560.0 мянган төгрөгийн 2 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг олон улсын НТШ-ЧҮСШ аргаар худалдан авахаар төлөвлөснөөс 13,563,537.8 мянган төгрөгийн 1 худалдан авалт хийж 50.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Дотоодын НТШ-ын 6 ажил, НТШ-ЧҮСШ-ын 1, ЧСШ-ын 2, нийт 3 зөвлөх үйлчилгээ, Харьцуулалтын аргаар худалдан авах 1 бараа, нийт 46,695,859.2 мянган төгрөгийн төсөвтэй 10 худалдан авах ажиллагаа хэрэгжээгүй, тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 36.8 хувь байна.

Худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**Илрүүлэлт:** Төслийн удирдах хорооны 2025 оны 01/25 дугаар тогтоолоор баталсан тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 358,618,687.2 мянган төгрөгийн 19 бараа, ажил, үйлчилгээ тусгагдсанаас гүйцэтгэлээр 299,357,347.0 мянган төгрөгийн 7 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь 36.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь төслийн үйл ажиллагаа удаашрах, төсөл хугацаандаа хэрэгжихгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч баталсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 21 дүгээр зүйлийн 21.2-т "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг" гэж тус тус заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, зохион байгуулж, төслийг үр ашигтай хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын тээвэр холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн томилолтын тооцоог бодож, ажлын тайлан, анхан шатны баримтыг үндэслэн томилолтын тооцоог хааж, данс бүртгэлд тусгаж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын тээвэр холболт ба логистикийг сайжруулах төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03/395 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал, цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 21,965,220.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 219,652.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын тээвэр холболт ба логистикийг сайжруулах төсөл нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглох зүйлс”-ийг зөрчөөгүй, хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж ажилласан бөгөөд зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар илэрсэн нийт 15,136,156.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөв.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,136,156.1 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй, өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны цахим системд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж тус тус заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд ил тод байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 71,429.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлснээс ажилтнуудад олгосон цалин, хөлснөөс дутуу суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн суутгаж, тайлагнах 6,485.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж хэрэгжээгүй, нийт биелэлт 50.0 хувь байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дд	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	2	71,429.8	1	6,485.8	50.0
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>71,429.8</b>	<b>1</b>	<b>6,485.8</b>	<b>50.0</b>

Өмнөх аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын тээвэр холболт ба логистикийг сайжруулах төслийн Бүрэлдэхүүн-1 хэсэг Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын /улсын чанартай нийт 361 км авто зам, нийт 1205.2 у/м, 7 гүүрийг шинэчлэн сайжруулах засварын ажил, нийт 51 км 2 сумыг холбох орон нутгийн чанартай авто зам барих болон хөрөнгийн менежментийг сайжруулах санал, зөвлөмж, дүрэм, журам

боловсруулах/ ажлын хүрээнд авто замын засварын ажлын 6 гэрээ, Авто замын дэд бүтцийн хөрөнгийн менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний 1 гэрээ байгуулагдсан.

Тайлант онд гүйцэтгэгчид ажлын талбайг хүлээлгэн өгөх, зураг төсөл боловсруулах зэрэг барилгын ажлын бэлтгэж хангасан бөгөөд дараагийн аудитаар ажил болон зөвлөх үйлчилгээний гэрээний гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нарийвчлан шалгана.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 5,148,014.9 мянган төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх загварын дагуу бэлтгээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан төсөв, гүйцэтгэлээр зэрэгцүүлээгүй;
- Өмнөх оны гадаад зээлийн санхүүжилтийн орлогыг Сангийн яамтай хийсэн тооцоо нийлсэн актаас зөрүүтэй, санхүүгийн үр дүнгийн тайланд 850,977.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд гадаад зээлийн санхүүжилтийн орлогыг 27,919,781.0 мянган төгрөг буюу 4,290,521.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Тайлант онд худалдан авч үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн 538.0 мянган төгрөгийн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан;
- Тайлант оны тендер шалгаруулалттай холбоотой гарсан зардал 5,523.6 мянган төгрөг, банкны шимтгэл 454.1 мянган төгрөг, нийт 5,977.7 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд гадаад валютын ханшийн зөрүүний гарзаар тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-1-ийн 1.21 "Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын, үр дүнгийн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан ба батлагдсан төсвийг олон нийтэд тайлагнахдаа төсөв болон гүйцэтгэлийн дүнгийн харьцуулалтыг тусад нь нэмэлт тайлангаар эсвэл санхүүгийн тайлан дээр нэмэлт баганаар харуулах, НББ-ийн бодлого ба санхүүгийн тайлангийн тэмдэглэл", 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 21,177,363.1 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрсэнд ажил гүйцэтгэх гэрээний урьдчилгаа төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 21,153,853.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, Томилолтын тооцоог бодоогүй, ажлын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томилолтын тооцоог хаасан зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 21,177,363.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 219,652.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Тайлант онд авто замын засварын ажил гүйцэтгэх 4 гэрээний урьдчилгаа төлбөрт төлсөн 21,153,853.1 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Анхан шатны баримтын бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Тайлант онд дотоод албан томилолтын зардал 23,510.0 мянган төгрөг тайлагнасан бөгөөд томилолтын тооцоо бодоогүй, удирдамж, тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Томилолтын тооцоог бодоогүй, ажлын тайлангүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар томилолтын тооцоог хааж, данс бүртгэлд тусгахгүй байх.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
								Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх загварын дагуу бэлтгээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан төсөв, гүйцэтгэлээр зэрэгцүүлээгүй байна.	1	-			1	-	1	-				
2	Өмнөх оны гадаад зээлийн санхүүжилтийн орлогыг Сангийн яамтай хийсэн тооцоо нийлсэн актаас зөрүүтэй, санхүүгийн үр дүнгийн тайланд 850,977.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	850,977.5	1	850,977.5			1	850,977.5				
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд гадаад зээлийн санхүүжилтийн орлогыг 27,919,781.0 мянган төгрөг буюу 4,290,521.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	4,290,521.0			1	4,290,521.0	1	4,290,521.0				
4	Тайлант онд худалдан авч үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн 538.0 мянган төгрөгийн хөрөнгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнасан байна.	1	538.0			1	538.0	1	538.0				
5	Тайлант оны тендер шалгаруулалттай холбоотой гарсан зардал 5,523.6 мянган төгрөг, банкны шимтгэл 454.1 мянган төгрөг, нийт 5,977.7 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд гадаад валютын ханшийн зөрүүний гарзаар тайлагнасан байна.	1	5,978.4			1	5,978.4	1	5,978.4				
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>5,148,014.9</b>	<b>1</b>	<b>850,977.5</b>	<b>4</b>	<b>4,297,037.4</b>	<b>5</b>	<b>5,148,014.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд байгуулсан ажил гүйцэтгэх 6, зөвлөх үйлчилгээний 1 гэрээ, гэрээний бүртгэлийг аудитын явцад ирүүлээгүй, авто замын засварын ажлын 4 гэрээний урьдчилгаа төлбөрт China road and bridge corporation-д 11,366,617.3 мянган төгрөг, China first highway engineering Co.,Ltd-д 3,803,374.6 мянган төгрөг, Shandong Luqiao Group Co.,Ltd-д 5,893,861.3 мянган төгрөг, нийт 21,153,853.1 мянган төгрөг төлснийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	21,153,853.1			1	21,153,853.1						
2	Тайлант онд дотоод албан томилолтын зардал 23,510.0 мянган төгрөг тайлагнасан бөгөөд томилолтын тооцоо бодоогүй, удирдамж, тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.	1	23,510.0					1	23,510.0				
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>21,177,363.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>21,153,853.1</b>	<b>1</b>	<b>23,510.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт												
1	Төслийн удирдах хорооны 2025 оны 01/25 дугаар тогтоолоор баталсан тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 358,618,687.2 мянган төгрөгийн 19 бараа, ажил, үйлчилгээ тусгагдсанаас гүйцэтгэлээр 299,357,347.0 мянган төгрөгийн 7 худалдан авалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь 36.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь төслийн үйл ажиллагаа удаашрах, төсөл хугацаандаа хэрэгжихгүй болох эрсдэлтэй байна.	1	-							1	-	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
2	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гэсэн 2 мэдээг хугацаа хоцроосон. Оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,136,156.1 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.	1	15,136,156.1					1	15,136,156.1			
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>15,136,156.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>15,136,156.1</b>	<b>1</b>	<b>15,136,156.1</b>	<b>1</b>	<b>-</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1169/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/34/НА - СТА - ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд авто замын засварын ажил гүйцэтгэх 4 гэрээний урьдчилгаа төлбөрт төлсөн 21,153,853,140.00 /Хорин нэгэн тэрбум нэг зуун тавин гурван сая найман зуун тавин гурван мянга нэг зуун дөчин/ төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилж гарсан төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн зохицуулагч /Б.Оюундэлгэр/, Санхүүгийн ажилтан /Б.Уянга/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1170/А0150053

Улаанбаатар хот

САГ -2026/34/НА-СТА-ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,136,156,149.00 /Арван таван тэрбум нэг зуун гучин зургаан сая нэг зуун тавин зургаан мянга нэг зуун дөчин есөн/ төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийн зохицуулагч /Б.Оюундэлгэр/, Санхүүгийн ажилтан /Б.Уянга/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-40.Docx

1526181824